



МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2014 оны 03 сарын 26 өдөр

Дугаар 111

Улаанбаатар хот

“Хорго Хайрхан” ХК-ийн нэгдмэл сонирхолтой  
хувьцаа эзэмшигчдээс Компанийн тухай хуулийн

57.1 дэх заалтыг хэрэгжүүлэх, хувьцааг худалдан авах саналыг зөвшөөрөх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, 6.1.2, Компанийн тухай хуулийн 57.1 дэх заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Хорго Хайрхан” ХК-ийн нийт гаргасан 135,126 ширхэг хувьцааны 67,5 хувь буюу 91,240 ширхэг хувьцааг эзэмшигч нэгдмэл сонирхолтой этгээд болох иргэн О.Тунгалаг, Р.Ариунболд болон иргэн Р.Батболд нараас тус хувьцаат компанийн бусад хувьцаа эзэмшигчдийн өмчлөлд байгаа нийт хувьцааны 32,5 хувь буюу 43,886 ширхэг хувьцааг нэг бүрийг нь 130 /нэг зуун гуч/ төгрөгөөс доошгүй үнээр худалдан авах санал гаргасныг зөвшөөрч хүчинтэй байх хугацааг 2014 оны 03 дугаар сарын 26-ны өдрөөс эхлэн ажлын 60 хоногоор тогтоосугай.

2. “Хорго Хайрхан” ХК-ийн нэгдмэл сонирхолтой этгээдүүдээс бусад хувьцаа эзэмшигчдийн хувьцааг худалдан авах санал гаргаж байгаатай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг нэгдмэл сонирхолтой этгээдүүдийг төлөөлж буй этгээд /Р.Ариунболд/-д үүрэг болгосугай.

1/ Компанийн тухай хуулийн 57.3-т заасны дагуу хувьцааг худалдан авах саналаа нийтэд сурталчилж, хуулиар хүлээсэн үүргээ хугацаанд нь биелүүлэх, хувьцааг худалдан авах саналын хугацаа дуусмагц ажлын 5 хоногт багтаан хувьцааг худалдан авах саналын хэрэгжилтийн тайланг Хороонд ирүүлэх;

2/ Санхүүгийн зохицуулах хорооны 2007 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Үнэт цаасны зах зээлийн мэдээллийн нэгдсэн сангийн тухай журам”-д заасан мэдээллийг цаг тухайд нь тогтмол ирүүлж, хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ чанд биелүүлж ажиллах;

3/ Санхүүгийн зохицуулах хорооны 2007 оны 210 дугаар тогтоолоор батлагдсан “Монголын компанийн засаглалын кодекс”-ыг мөрдөж ажиллах.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

000110